



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/543

Есөнбулаг

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Бигэр сумд жимс, жимсгэнэ хамгаалалтын ойн зурваст тарих тарьц суулгац үржүүлэх мод үржүүлгийн газар байгуулах, агро ойн аж ахуйг өргөжүүлэх ажлыг "Бигэр шимт элс" ХХК, Баянтоорой тосгонд говийн мод сөөг ховор ургамлын үржүүлгийн бааз байгуулах ажлыг "Ихэр марал" ХХК, Халиун сумд жимс, жимсгэнэ хамгаалалтын ойн зурваст тарих тарьц, суулгац үржүүлэх мод үржүүлгийн газар байгуулах ажлыг "Нутгийн төгөл" ХХК тус бүр хийж гүйцэтгэсэн ажлыг хүлээж авах коммисыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Хаш-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:	Б.Цэрэнбал	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль орчин, геологи, уул уурхай, аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн)
	М.Мандаххүү	(Аймгийн Засаг Даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	Д.Батмагнай	(Байгаль орчны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Х.Нордогбат	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын газар тариалангийн үйлдвэрлэл техник технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
	Ж.Билэгсайхан	(Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн)
	Б.Эрдэнэчимэг	(Сум дундын ойн ангийн мэргэжилтэн)
	Г.Мөнхбаяр	(Бигэр сумын Засаг дарга)
	Б. Мянганбаяр	(Халиун сумын Засаг дарга)
	Ш.Насанбуян	(Цогт сумын Засаг дарга)
	Ж.Очир	("Бигэр шимт элс" ХХК-ийн захирал) (Гүйцэтгэгч)

2.

Б.Доржсүрэн ("Ихэр марал" ХХК-ийн захирал)
(Гүйцэтгэгч)

Ц.Батсайхан ("Нутгийн төгөл" ХХК-ийн захирал)
(Гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: Б.Пүрэвдорж (Байгаль орчны газрын ой, ургамал,
байгалийн гамшигийн асуудал
хариуцсан мэргэжилтэн)

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн Бигэр, Цогт, Халиун сумдад шинээр мод үржүүлгийн газар байгуулах ажлыг хүлээн авахдаа ажлын даалгавар, гэрээнд тусгагдсан ажлын гүйцэтгэл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3. Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг бүртгэж, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг Бигэр сумын Засаг дарга (Г.Мөнхбаяр)-д, Цогт сумын Засаг дарга (Ш.Насанбуян)-д, Халиун сумын Засаг дарга (Б.Мянганбаяр)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г ЧИНБАТ